

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

1999 оны 03 дугаар
сарын 04-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Журам тогтоох тухай

Хувьцааны арилжаанд нь маргаан гарсан ХК-ийн хувьцааг Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчаас болон эрх бүхий хууль хяналтын байгууллагаас тусгаарласан, хувьцаат компанийн энгийн хувьцааг банкаас зээл авахад барьцаалсан үед тухайн хувьцааны саналын эрхийн талаар хувьцаат компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчээс өргөдөл, гомдол гарах болсныг нэг мөр болгон журамлах зорилгоор Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5,6,8 дахь заалтыг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

~~1. Эрх бүхий этгээдийн шийдвэрээр тусгаарлагдаад байгаа хувьцааны саналын эрхийг уг хувьцаатай холбогдох маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл түдгэлзсэнд тооцож байсугай.~~

1. Эрх бүхий этгээдийн шийдвэрээр тусгаарлагдаад байгаа хувьцаа нь саналын эрхтэй байна. Тусгаарлагдсан хувьцааг эзэмшигч этгээдийн оролцсон хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэр нь бусад хувь нийлүүлэгчдийн болон нэхэмжлэгчийн эрх ашгийг хохироосон гэж үзвэл Хороо хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу холбогдох арга хэмжээ авна.

/Үнэт цаасны хорооны 2001 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

2. Хувьцаат компанийн энгийн хувьцаа нь зээлийн барьцаанд байгаа үед тэдгээрт ногдох саналын эрхийг түдгэлзүүлэх эсэх, саналын эрхийг эдлэх этгээдийн тухай асуудлыг тухайн хувьцааг барьцаалах тухай гэрээнд тусгаж байхаар 1999 оны 3 дугаар сард багтаан холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулж мөрдөхийг Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөл /Г.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-нд даалгасугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

